



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/345

Номгон

Нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 32 дугаар зүйлийн 32.1.9, аймгийн Засаг даргын 2020 оны А/761 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан аймгийн Онцгой комиссын гишүүдийг нэмж, зарим шуурхай ажлын хэсэгт өөрчлөлт оруулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны “Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам, ажлын хэсэг, алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай” А/761 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын гишүүд хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга”, “Боловсрол, соёл урлагийн газрын дарга” гэж, 3 дугаар хавсралтын 4 дүгээр ажлын хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга”, “Боловсрол, соёл урлагийн газрын дарга”, 11 дүгээр ажлын хэсэгт “Боловсрол, соёл урлагийн газрын дарга” гэж;

3. Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны “Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” А/200 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын “Шуурхай штабын бүрэлдэхүүн” хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын “Цэргийн штаб”-ын Тоо бүртгэлийн офицер, хошууч М.Мөнхбатыг “Шуурхай штаб”-ын “Бэлэн байдал хариуцсан офицер”-оор нэмж тус тус өөрчилсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



М. МӨНХСАЙХАН

621010877